

**ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АСУУДАЛ**
THE ISSUE OF ENSURING THE SECURITY OF THE COURT



Б.ЦЭРЭНДОРЖ

ЦЕГ-ын НХЖХОлон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны эргүүл хамгаалалтын газрын Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн хамгаалалтын офицер, цагдаагийн ахмад

Товч агууллага: Энэхүү өгүүлэлд шүүхийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг хуульчилж ирсэн байдал, шүүхийн аюулгүй байдлыг бүрдүүлэгч хэсгүүд, шүүх хуралдааны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүдийг судалж, зарим дүгнэлт хийж, санал дэвшүүлэв.

Түлхүүр үг: Шүүх, аюулгүй байдал, гэмт этгээд, шүүх хуралдааны дэг журам.

Abstract: The report examines the factors that may affect the security of judicial security, the elements of judicial security and the security of the judicial session

Key word: judicial, security, criminal and procedural rules

Ардчилсан шударга шүүхийн гол зарчим нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал юм. Энэхүү зарчим алдагдсан тохиолдолд эрх мэдлийг хуваарилах зарчим, алдагдах, нийгмийн ёс, дэг журам, сахилга хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болох, хээл хахууль газар авч гэмт хэрэг зохион байгуулалттай болох зэрэг дотоод аюулгүй байдал алдагдах нөхцөл бүрдэх юм.

Шүүхийн аюулгүй байдал гэдэг ойлголт нь үндсэн агуулгын хувьд шүүх, шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, шүүх хуралдааны дэг, журмыг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, хуяглан хүргэх зэрэг олон талт харилцааг хамарсан байдаг.

Хүчингүй болсон Тахарын албаны тухай хуулийн 3.1.1 “шүүхийн аюулгүй байдал” гэж шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, шүүхийн харуул хамгаалалт, барилга байгууламж, түүний орчны аюулгүй байдлыг хэлнэ гэсэн байна¹.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журамд зааснаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг бүрэлдүүлэгч хэсэгт шүүх, шүүхийн байгууламжийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах, шүүх хуралдааны дэг журам сахиулах, шүүх, шүүх бүрэлдэхүүнийг аюулгүй байдлыг хангах зэргийг хамааруулсан байна².

Гэмт хэрэгтнүүдийн үйлдэх гэмт хэрэг улам нарийсч, бүлэглэлийн шинжтэй болсон талаар мэдээлэл жил ирэх тусам нэмэгдсээр байна. Сүүлийн жилүүдэд хүчирхийлэх, хүнийг санаатай алах, ёс бус арга хэрэглэн хэрцгийгээр амь насыг нь хохироох, амиа хорлоход хүргэх зэрэг гэмт хэрэг нэмэгдсээр байна. Гэтэл эдгээр гэмт хэргүүдийг үйлдсэн этгээдүүд шүүн таслах ажиллагааны үеэр шүүх танхимд зогсдог. Шүүх танхимд байгаа хүмүүсийн, тухайлбал хэргийг шүүж буй даргалагч шүүгч, шүүгч нарын, гэмт хэргийн хохирогч эсхүл хохирогчийн ар гэрийн гишүүд, улсын нэрийн өмнөөс оролцож буй прокурор, талуудын өмгөөлөгч, тэнд байгаа иргэдийн аюулгүй байдал бүрэн хангагдсан эсэх нь эргэлзээ дагуулж байгаа юм.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг хуульчилж ирсэн байдлыг судлан авч үзвэл 2014 оноос өмнө шүүхээс хүсэлт тавьж шүүх хуралдааны шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах зорилгоор Аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга нь тухайн нутаг дэвсгэрийн шүүхэд ажиллах хуягийн тоог холбогдох шүүхийн тамгын хэлтсийн даргатай тохиролцож тогтоосны үндсэн дээр цагдаагийн алба хаагчийг шүүхийн хуягаар ажиллуулахаар нэг жилийн хугацаатай томилон ажиллуулж байв.

Харин 2014 оны 04 сард эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Тахарын алба гэх шинэлэг байгууллага байгуулагдан Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах тусгай хуулийг баталж дэвшилттэй үйл явдал болсон бөгөөд зөвхөн шүүгчийн бус гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин

¹ Тахарын албаны тухай хууль // <https://www.legalinfo.mn/law/details/9286>

² Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам // <https://www.legalinfo.mn/annex/details/7418?lawid=12157>

бүрдсэн байсан юм. Гэвч 2016 онд Тахарын албаны тухай хууль хүчингүй болж Тахарын албыг татан буулгаж Цагдаагийн байгууллагад тус байгууллагын чиг үүргийг шилжүүлсэн юм. Зарим судлаачид энэ явдлыг шинэчлэлийн алхмаасаа ухарсан гэж үздэг бөгөөд зарим нь эргэн нэгтгэж төсөв хэмнэсэн нь зөв гэсэн зарчим, үзэл бодлын хувьд сөргөлддөг.

Шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах асуудлыг тусгайлан авч үзвэл өнөөдрийн байдлаар Цагдаагийн алба хаагчид шүүх шүүгчийн аюулгүй байдлыг ямар арга хэмжээгээр хэрхэн хангах нь хуульчлагдаагүй хоцорсон бөгөөд Хууль Зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар батлагдсан шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах журманд зааснаар ажиллаж байгаа бөгөөд Шүүх хуралдааны аюулгүй байдлыг ханган, шүүх хуралдааны дэг журмыг сахиулахад Цагдаагын байгууллага Шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг ханганшүүн таслах ажилгааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан байдаг.

Харин шүүх хуралдааны дэг журам гэдэгт шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирснээс эхлэн шүүх хуралдаан хаах хүртэлх хугацаанд явагдаж байгаа хянан харгалзах журам сахиулахтай холбогдсон цогц ажиллагааг ойлгодог. Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах журамд цагдаагийн байгууллага, алба хаагчийн чиг үүрэг зэргийг заасан байдаг.

Эргүүл хамгаалалтын газрын, Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс нь 98 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээс Шүүгч шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах тасаг нь 8 офицер 38 цагдаагийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийт 10 шүүхийн байр байдаг ба эрүү, иргэн, захиргаа, давж заалдах болон Улсын дээд шүүх нийт 50 шүүх хуралдааны танхимтайгаас 30 шүүх хуралдааны танхимд, дэг журмыг сахиулан ажиллаж байна. Шүүх хуралдаан бүрт дэг журам сахиулж ажиллах боломжгүй хүн хүч хүрэхгүй байгаагаас үүдэн 3 шүүх хуралдааны танхимын дунд нэг цагдаагийн алба хаагч ажиллан гаднаас телекамераар хяналт тавьж ажиллаж байна.

Жишээ нь: Баянзүрх Сүхбаатар Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь шүүх хуралдааны 6 танхимтай, шүүгдэгч яллагдагчийг хүлээн авах түр саатуулах өрөө 1 байдаг ба 1 офицер 5 хамгаалалтын цагдаа ажиллаж байна. Нэг хамгаалалтын цагдаа түр

саатуулах байранд үүрэг гүйцэтгэн ажилхад 4 цагдаа шүүх хуралдааны 6 танхимд дэг журам сахиулан ажилладаг.

Мөн шүүгчийн ёс зүйн хорооны хуралдаанд гомдол гаргагч, шүүгч оролцдог тул аюулгүй байдлыг ханган цагдаагийн алба хаагч оролцдог.

Гэтэл Монгол Улсад сүүлийн жилүүдэд шүүн таслах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, шүүгчийн биед халдсан гэмт хэрэг, зөрчлүүд гарсаар байна. Тухайлбал, Тахарын ерөнхий газар үйл ажиллагаагаа явуулж байх хугацаандаа 2 шүүгч, 2 улсын яллагч, 5 гэрч, 26 хохирогч, 29 хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг.

Олон улсын туршлагаас харахад онц ноцтой гэмт хэргийг үнэн зөв, шударгаар шийдвэрлэх, бие даасан шүүх, хараат бус шүүгчийн үйл ажиллагааны гол хүчин зүйл нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах явдал гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлийн тусгай албыг байгуулан ажиллуулж, аюулгүй байдлыг хангах асуудалд онцгойлон анхаарч ажилладаг юм. Жишээ нь: ОХУ-д Шүүхийн дэргэд хууль сахиулах алба, Франц улсад Үндэсний Жандармын алба, Канад Улсад Шерифийн алба, АНУ-д Маршалын алба тус тус шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах нь нэг удаагийн шинжтэй бус байнгын тогтмол үйл ажиллагаа тул энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай алба тодорхой стратегитай, гэмт халдлагын нөхцөл байдалтай уялдаж ажиллах шаардлагатай байдаг.

Гэтэл Монгол Улсад нөхцөл байдал эсрэгээр байна. 2016 онд Тахарын албыг татан буулгасан, Цагдаагийн албаны тухай хуульд шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тусгасан боловч алба хаагчийн эрх, үүрэг хэсэгт шүүх хуралдааны аюулгүй байдлыг хэрхэн хангах, дэг сахиулах, шүүх танхимыг, байрыг хэрхэн хамгаалах зэрэг зохицуулалт байхгүй байна.

Монгол улсын дээд шүүхийн хуралдааны дэг 15 дугаар зүйлд зааснаар дээд шүүхийн хуралдааны дэг журмыг сахиулах, оролцогсдын аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүхийн хуягийг ажиллуулах буюу цагдаагийн байгууллагын туслалцаа авч болно гэсэн заалтын дагуу цагдаагийн алба хаагч томилогдон ажиллаж байна. Үүнд орхигдсон нэгэн зүйлийг үзвэл анхан шатнаас гарсан хорих ял шийтгүүлсэн шүүхийн шийдвэрийг давж заалдах шатнаас хэрэгсэхгүй болгон сулладаг ба уг шийдвэрийг эсэргүүцэн дээд шүүхэд гомдол гарган хуралдахад, давж заалдах шатны шүүхийн

захирамжийг хэрэгсэхгүй болгон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхэд, давж заалдах шатны шүүхээс суллагдсан этгээд ял завшин үлдэх асуудал гарч байгаа нь зохицуулалтгүй үлдэж байна.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн ахлах судлаач, хуульч Л.Галбаатар өөрийн өгсөн ярилцлагадаа Аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааны дэг журмыг сахиулах нь хамгаалалтын цагдаагийн үүрэг болохыг “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-д тодорхой заасан. Шүүх хуралдааны үеэр яллагдагч амиа хорлохыг завдсан үйлдэл нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд мэргэшсэн албан хаагч чухал болохыг нотолсон зүйл боллоо. Өөрийгөө хэрчих битгий хэл шүүгчийн хоолойг хэрчихэд бэлэн байгааг харуулж байна. Одоо үйлчилж байгаа Цагдаагийн албаны тухай хуульд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар ганц ч үг, үсэг байхгүй гэж тэмдэглэсэн байдаг³.

Тухайн хэрэг явдлын талаар Г.Батмандах нийтлэлдээ тэмдэглэсэн байдаг бөгөөд тус явдлын үеэр шүүгдэгч хоолойгоо зүсч, ширээ сандал өшиглөж байхад ганц цагдаа ноцолдож харагдсан. Шүүгчид яах учраа олохгүй самгардаж, нэг нь өнөөх амиа хорлохыг завдагчийн дэргэдүүр алхаж байсан. Хэрэв тухай этгээд тэр шүүгчид халдсан бол ганц цагдаа хорьж дийлэх үү. Энэ мэт шүүх танхимд юу ч болох хэнд ч халдах эрсдэл байна гэж онцолсон байна⁴.

Мөн дахин нэг хөндөхгүй орхиж болохгүй асуудал нь шүүхийн байранд шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, аюулгүй байдлыг хангахад шаардагдах техник хэрэгсэл юм. Өнөөдрийн байдлаар аймаг, дүүргийн шүүхүүдэд иргэдийг нэвтрэхэд шалгах төхөөрөмж, металл илрүүлэгч зэрэг хэрэгслүүд дутуу байгаа шүүгдэгч, бусад хүмүүс галт зэвсэг, хутга мэс, бүр тэсрэх бөмбөг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Иймд шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлж ажиллахын тулд, цагдаагийн байгууллагаас хүн хүч нэмэгдүүлэх шүүх хуралдааны танхимын тоогоор хамгаалалтын цагдааг нэмж томилон ажиллах нь нэн түрүүн тавих шаардлагатай болж байна. Шүүх хуралдааны үед шүүгдэгч ялтан өөрийн бие амь насанд гэмтэл учруулах шүүх хуралдааны дараа шүүгчийн өрөө тасалгаанд орж дарамтлах, шүүгчид

³ <http://www.judcouncil.mn/main/5007--.html>

⁴ <https://news.mn/r/760231/>

нөлөөлөх, гэх мэт үйлдлүүд удаа дараа гарч байгаа нь хүн хүч дутмаг байгааг илэрхийлсээр байна.

Сайн туршлагаас дурдвал шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах байдлыг сайжруулах тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байгаа. Жишээ дурдвал: Тахарын алба татан буугдаж тус байгууллагын чиг үүргийг хүлээн авсан цагдаагийн байгууллагаас шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах, алба хаагчдад мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн цагдаагийн газруудад дадлага сургалтыг зохион байгуулсаар байна. Тухайлбал, 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Дорнод аймаг дахь Цагдаагийн газраас аймгийн Шүүхийн байгууллагатай хамтран дадлага сургалтыг зохион байгуулсан байна. Тухайн сургалтаар шүүгдэгч амиа хорлох үйлдлийг таслан зогсоох, олон нийтийн анхаарал татсан шүүх хуралдаанд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцож буй иргэд шүүх хуралдааны дэг, журам зөрчсөн үед таслан зогсоох зэрэг сэдвийн хүрээнд явагдсан⁵.

Шүүх хуралдааны аюулгүй байдлыг сайжруулахад дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дээр дурдсанчлан шүүхийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь шүүх хуралдааны журам сахиулах, шүүхийн харуул хамгаалалт, барилга байгууламж, түүний орчны аюулгүй байдлыг ойлгодог. Шүүх хуралдааны аюулгүй байдал зөвхөн шүүх танхимд болж байгаа процессоос бус шүүхийн барилга, байгууламж, аюулгүй байдал, харуул хамгаалалтаас шалтгаалах учир шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх;

2. Металл ирлүүлэгч хаалга, гар металл илрүүлэгч, шүүгдэгчийн суух хэсгийн тусгаарлагч хаалт хийх, шүүхийн байрлуу нэвтэрч байгаа иргэдийн гар тээшийг хадгалах электрон шүүгээ зэргээр шүүхийн байруудыг хангах;

3. Шүүхийн аюулгүй байдлыг хангах сургалтуудыг тогтмол зохион байгуулах зэрэг болно.

⁵ <https://police.gov.mn/a/2580>